



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@moj.gov.mn,
http://www.moj.gov.mn

2016.04.22 № 3/1675

танай _____-ны № _____-т

ИРГЭНИЙ ХАРЬЯАЛАЛ, ШИЛЖИЛТ
ХӨДӨЛГӨӨНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Д.БОЛД ТАНАА

“Дипломат болон албан паспорт
эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай
Монгол Улсын Засгийн газар, Унгар Улсын Засгийн
газар хоорондын хэлэлцээр” 2016 оны 5 дугаар
сарын 18-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчлэх
болсныг мэдэгдэж хэлэлцээрийг хуулбарыг танай
ажлын хэрэгцээнд зориулан хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт: 4 хуудас.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ГЭРЭЭ ЭРХ ЗҮЙ, ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.ЦЭЦГЭЭ



Doc.yam a5 2016
18 1862



**ДИПЛОМАТ БОЛОН АЛБАН ПАСПОРТ ЭЗЭМШИГЧДИЙГ
ВИЗИЙН ШААРДЛАГААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, УНГАР УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Унгар Улсын Засгийн газар, цаашид "Тал" эсхүл "Талууд" гэх.

Хоёр улсын хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны цаашдын хөгжлийг дэмжихийг эрмэлзэж,

Талуудын дипломат болон албан паспорт эзэмшигч иргэдийг хоёр улсын нутаг дэвсгэрт зорчих нөхцөлийг хөнгөвчлөхийг зорьж,

дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Энэхүү хэлэлцээрийн заалтуудыг хүчин төгөлдөр Монгол Улсын дипломат болон албан паспорт, Унгар Улсын дипломат болон сервис паспортын хувьд хэрэглэнэ.

2 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд дурдсан паспорт эзэмшигч Талуудын аль нэг улсын иргэд зуун ная (180) хоногийн хугацаанд ер (90) хүртэлх хоног нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин суух зөвшөөрөлгүйгээр зорчих болон визгүй нэвтрэх, гарах, дамжин өгөх эрхтэй. Энэхүү зуун ная (180) хоногийн хугацааг тухайн иргэний зорчсон эхний өдрөөс эхлэн тооцно.

3 дугаар зүйл

Нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа Дипломат төлөөлөгчийн газар, Консулын төлөөлөгчийн газар болон Олон улсын байгууллагад ажиллахаар томилогдсон аль нэг Талын хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигч иргэд болон тэдгээрийн хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигч гэр бүлийн гишүүд хүлээн авагч улсад ирэхээсээ өмнө зөвшөөрөл (аккредитаци)-ийн виз авах үүргээс энэхүү хэлэлцээрээр чөлөөлөгдөхгүй.

4 дүгээр зүйл

(1) Энэхүү хэлэлцээрийн 2 дугаар зүйлд дурдсан аль нэг Талын улсын иргэд нөгөө Талын нутаг дэвсгэрт олон улсын тээвэрт зориулагдсан хилийн боомтоор нэвтрэх эрхтэй.

(2) Энэхүү хэлэлцээрийн 2 дугаар зүйлд дурдсан иргэд нөгөө Талын нутаг дэвсгэрт нэвтрэн орох өдрөөс хойш доод тал нь зургаан (6) сарын хүчинтэй хугацаатай паспорт эзэмшиж байх ёстой.

5 дугаар зүйл

(1) Талууд энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш гуч (30) хоногийн дотор хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд дурдсан паспортын загварыг дипломат шугамаар харилцан солилцоно.

(2) Аль нэг Тал шинэ загварын дипломат болон албан паспорт нэвтрүүлэх тохиолдолд шинэ загварын паспорт нэвтрүүлэхээс доод тал нь гуч (30) хоногийн өмнө нөгөө Талд эдгээр паспортын загварыг дипломат шугамаар хүргүүлнэ.

6 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрээр аль нэг Талын улсын хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигч иргэд нөгөө Талын улсын нутаг дэвсгэрт зорчих хугацаандаа гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэх, түр хугацаагаар зорчих, нэвтрэхтэй холбогдох хүчин төгөлдөр үйлчилж буй нөгөө Талын улсын хууль тогтоомж болон журмыг хүндэтгэх үүргээс чөлөөлөгдөхгүй.

7 дугаар зүйл

(1) Энэхүү хэлэлцээр нь түүний нутаг дэвсгэрт байх нь тааламжгүй гэж үзсэн иргэдийг өөрийн нутаг дэвсгэрт нэвтрэх, зорчих, дамжин өнгөрөхийг зөвшөөрхөөс татгалзах Талуудын эрхийг хөндөхгүй.

(2) Тал тус бүр үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эсхүл олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор нөгөө Талын улсын иргэдийг орох, зорчих, дамжин өнгөрөхөөс татгалзах эрхтэй.

(3) Аль нэг Тал үндэсний аюулгүй байдал, нийтийн дэг журам, эсхүл олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн зогсоох эрхтэй. Ийм арга хэмжээ авсан болон хэлэлцээрийг сэргээсэн тухайгаа гурван (3) өдрийн дотор нөгөө Талдаа дипломат шугамаар мэдэгдэнэ.

8 дугаар зүйл

Нөгөө Талын нутаг дэвсгэрт дипломат болон албан паспортаа алдсан болон үрэгдүүлсэн иргэн өөрийн улсын дипломат болон консулын төлөөлөгчийн газраар дамжуулан хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. Тухайн иргэнийг эх орондоо буцах боломжтой болгох үүднээс тус Дипломат болон Консулын төлөөлөгчийн газар тухайн иргэнд зорчих баримт бичиг олгох бөгөөд хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагад даруй мэдэгдэнэ.

9 дүгээр зүйл

Энэхүү хэлэлцээр нь Унгар Улсын Европын холбооны гишүүний хувьд үүсэх аливаа эрх, үүргийг ямар нэгэн байдлаар хөндөхгүй.

10 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх болон тайлбарлахтай холбогдуулан Талууд хооронд үүсэх аливаа маргааныг олон улсын арбитрт, эсхүл аливаа гуравдагч этгээдэд шилжүүлэхгүйгээр Талууд хоорондоо шууд зөвлөлдөх болон хэлэлцэх замаар шийдвэрлэнэ.

11 дүгээр зүйл

(1) Энэхүү хэлэлцээрийг хугацаагүйгээр байгуулсан болно. Энэхүү хэлэлцээр нь Талууд түүнийг хүчин төгөлдөр болгох талаар дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа дипломат шугамаар харилцан

мэдэгдсэн сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш гуч (30) дахь өдөр хүчин төгөлдөр болно.

(2) Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсноор 1992 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр гарын үзэг зурсан Дипломат болон албан паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас харилцан чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Унгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр хүчингүй болно.

(3) Энэхүү хэлэлцээрт Талууд харилцан бичгээр тохиролцсоноор нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Аливаа нэмэлт, өөрчлөлтийг энэхүү хэлэлцээрийн салшгүй хэсэг гэж үзэх бөгөөд протокол хэлбэрээр байгуулна. Нэмэлт, өөрчлөлт нь энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хүчин төгөлдөр болно.

(4) Аль нэг Тал ямар ч үед нөгөө Талдаа дипломат шугамаар бичгээр мэдэгдэл хүргүүлснээр энэхүү хэлэлцээрийг цуцалж болно. Хэлэлцээрийг цуцлах тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ер (90) хоногийн дараа хүчингүй болно.

Улаанбаатар хотноо 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр монгол, унгар, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Хэлэлцээрийг тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

ЛҮНДЭГИЙН ПҮРЭВСҮРЭН
ГАДААД ХЭРГИЙН САЙД

УНГАР УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

ПЕТЕР БИЯАРТО
ГАДААД ХЭРЭГ, ХУДАЛДААНЫ
САЙД

БҮРТГЭЛИЙН КАРТ

Нэр төрөл:		Албан тоот			Хаанаас, хэнээс:		
					ХЗЯам, Г.Цэцгээ		
Хүлээж авсан огноо:		Бүртгэлийн дугаар:		Хаана, хэнд:			
2016.04.25		3988		ИХШХЕГазар			
Бүртгэсэн:				Бичгийн огноо:		Дугаар	
Болортуяа.Д				2016.04.22		Хуудас	
Товч утга:				3/1675		5.0	
Хэлэлцээр ирүүлсэн тухай.							
Удирдлагын заалт:							
Г.Төгөлдөр, Г.Ганболд, С.Хүсрэгзүрэг нар Харгалзах дүгнэлтийг хийж амжил.							
Шилжүүлсэн газар, нэгж:				Шилжүүлсэн огноо:			
Захиргаа удирдлагын газар				2016.04.25			
Хэнд шилжүүлсэн:							
Төгөлдөр.Г							

Гарын үсэг

(Signature)